

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 21-НИЙ
ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ТОЙМ**

Тус Байнгын хорооны 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 15 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийн хуралдаан 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 16.00 цагт Төрийн ордны “Г” танхимд болов.

Дэд ажлын хэсгийн хуралдаанд Эрүүл мэнд, спортын яамны стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Р.Оюунханд, Эрүүл мэнд, спортын яамны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Баяр, Эрүүл мэнд, спортын яамны эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэтуяа, Улсын II төв эмнэлгийн ерөнхий захирал Г.Баясгалан, Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын нийгмийн салбарын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Алтантуяа, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны ерөнхийлөгч С.Сонин, “Шинэ нийгэм-Эрүүл мэнд” төрийн бус байгууллагын тэргүүн С.Дуламсүрэн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны Ажлын албаны зөвлөх Ж.Чимгээ, референт А.Болортуяа нар оролцлоо.

Хуралдааныг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны Ажлын албаны зөвлөх Ж.Чимгээ удирдаж, зарчмын зөрүүтэй саналын талаар хэлэлцсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 23-ны Лхагва гарагт дахин хуралдахаар тогтов.

Ажлын дэд хэсгийн хуралдаан 17.05 цагт өндөрлөлөө.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны

Ажлын алба